



ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОГЧДОД

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

Ж.Самбуугийн гудамж-30, Бага тойруу,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201
Утас: 32-01-26, Факс: (976-11) 31-93-35,
Цахим шуудан: info@erc.gov.mn
Вэбсайт: erc.gov.mn

2022. 12. 06 № 1/1232
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Эрчим хүчний зохицуулах хороо, Диспетчерийн үндэсний төв ТӨХХК, Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хамтран “Эрчим хүчний хүрэлцээ ба хэмнэлт” зөвлөгөөнийг 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан билээ.


Тус зөвлөгөөнд Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Диспетчерийн үндэсний төв, Эрчим хүчний үндэсний төв, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Олон улсын байгууллагууд, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эрчим хүчний сургууль, Эрчим хүчний салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд, үүрэг хүлээсэн хэрэглэгчид, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын удирдлага, инженер техникийн ажилтнууд, эрдэмтэн судлаачдаас бүрдсэн нийт 230 төлөөлөгч танхимаар, 400 гаруй төлөөлөгч цахимаар оролцож эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж гаргалаа.

Зөвлөгөөнөөр хэлэлцэж баталсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, цаашид авах арга хэмжээний тухай асуудлыг Эрчим хүчний сайдын зөвлөлийн хуралд танилцуулан, гарсан шийдвэрийн хүрээнд та бүхэнтэй хамтран ажиллах болно.

Эрчим хүчний хүрэлцээ ба хэмнэлт зөвлөгөөнөөс гаргасан “ЗӨВЛӨМЖ”-ийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГА



Э.ТҮВШИНЧУЛУУН

220042511

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХҮРЭЛЦЭЭ БА ХЭМНЭЛТ” ЗӨВЛӨГӨӨНӨӨС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

2022.11.29

Улаанбаатар хот

“Эрчим хүчний хүрэлцээ ба хэмнэлт” зөвлөгөөнд Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Диспетчерийн үндэсний төв, Эрчим хүчний үндэсний төв, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Олон улсын байгууллагууд, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эрчим хүчний сургууль, Эрчим хүчний салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд, үүрэг хүлээсэн хэрэглэгчид, үйлдвэрлэх, дамжуулах түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын удирдлага, инженер техникийн ажилтнуудаас бүрдсэн нийт 230 төлөөлөгч танхимаар, 400 гаруй төлөөлөгч цахимаар оролцож дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хуулийн үйлчлэл, цар хүрээ, зохицуулалтын харилцаа, үр нөлөөг нэмэгдүүлэх замаар хэмнэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх. Үүнд:

- 1.1 Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүдийг боловсруулж, УИХ-д өргөн барих ажлыг зохион байгуулах /Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо/.
- 1.2 Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд заасан урамшууллын журмыг боловсруулж Засгийн газарт танилцуулах /Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо/.
- 1.3 Эрчим хүчний үр ашигтай бараа бүтээгдэхүүний шошго, стандартын тогтолцоог нэвтрүүлэх /Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо/.
- 1.4 Шинээр баригдах орон сууц, барилга байгууламжид цахилгаан, дулааны ухаалаг тоолуур суурилуулж байхаар барилгын норм ба дүрэмд тусгах, дулааны тоолуур суурилуулах боломжгүй орон сууцны өрөөний халаалтын хэрэглээг тодорхойлох халаалтын зардал хуваарилах хэрэгслийг хэрэглэгчийн дулааны төлбөрийг тооцоолоход ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх, дулааны эрчим хүчний бодит өртөг, зардалд суурилсан үнэ тарифыг тогтоож мөрдүүлэх, дулааны эрчим хүчний хөндлөн татаасыг арилгах арга хэмжээ авах /Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо/.
- 1.5 Хангагч хэрэглэгч хоорондын эрчим хүчээр хангах гэрээнд өөрчлөлт оруулах замаар оргил ачааллын үеийн хэрэглээг бууруулах эрх зүйн зохицуулалтыг 2023 оны 1 дүгээр улиралд бүрдүүлэх /Эрчим хүчний зохицуулах хороо, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид/.

Хоёр. Нэгдсэн сүлжээний өвлийн оргил ачааллын үеийн цахилгаан эрчим хүчний ачааллыг бууруулах зохицуулалтыг хэрэгжүүлэн эх үүсвэрийн чадлын дутагдал, импортын эрчим хүчний хамаарлыг багасгах, улмаар хэрэглээний өсөлтийг хангахад чиглэсэн нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх. Үүнд:

- 2.1 Хэрэглэгчдийн эрчим хүчний хэрэгцээг удирдах хөтөлбөрийг боловсруулж нэгдсэн сүлжээний оргил ачааллын үеийн хэрэглээг бууруулах диспетчерийн зохицуулалтыг 2022 оны 12 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж ажиллах /Диспетчерийн үндэсний төв ТӨХХК, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид/.
- 2.2 Айл өрхийн хэрэглээнд оргил цагийн тарифыг нэвтрүүлэх, хэрэглээнээс хамаарсан тарифын шатлалыг нэмэгдүүлж, эрчим хүчийг хэмнэх хөшүүргийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан бий болгох /Эрчим хүчний зохицуулах хороо/.
- 2.3 Оргил ачаалалд нөлөө үзүүлж буй аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийн эрчим хүчний хэрэглээг бууруулахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлэх /Эрчим хүчний зохицуулах хороо, Диспетчерийн үндэсний төв, цахилгаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид/.

Гурав. Эрчим хүчний салбарын хэмнэлт, үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх. Үүнд:

- 3.1 Эрчим хүчний салбарт 2023 оныг “Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн жил” болгон зарлах.
- 3.2 Эрчим хүчний дамжуулах, түгээх сүлжээний техникийн болон арилжааны алдагдлыг жил бүр бодитоор бууруулах, түүнээс бий болох хэмнэлтээр технологийн үр ашгаа сайжруулах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлэхэд зохицуулалтын бодлогоор дэмжих /Эрчим хүчний зохицуулах хороо/.
- 3.3 Эрчим хүч түгээх, хангах үйл ажиллагаанд ухаалаг тоолуурын системийг хэмнэлт, үр ашгаас гарсан хөрөнгөөс санхүүжүүлж 2023 оноос эхлэн хэрэгжүүлэх /түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид/.
- 3.4 Салбарын үйлдвэр, компани, байгууллагууд эрчим хүчний системийн оргил ачааллын үеийн хэрэглээгээ бууруулахад манлайлж, 2023 оноос төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх /салбарын байгууллагууд, тусгай зөвшөөрөл эзэмшигчид/.
- 3.5 Эрчим хүчний салбарын нягтлан бодох бүртгэлийн системийг олон улсын стандартад нийцүүлэх, хөрөнгийн менежментийг оновчтой болгох, зардлын хэмнэлт гаргах.
- 3.6 Төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаанаар хангагдаж буй хэрэглэгч ААНБ-уудыг тоолууржуулах, дулааны төлбөрийг тоолуураар хийх.

Дөрөв. Үүрэг хүлээсэн хэрэглэгч эрчим хүчийг хэмнэх, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх. Үүнд:

- 4.1 Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээний босго хэмжээг шинэчлэн тогтоож, эрчим хүч хэмнэх хэрэглэгчийг тоо, цар хүрээг нэмэгдүүлэх /Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо/.

- 4.2 Үүрэг хүлээсэн хэрэглэгчдэд жилд бүр хэмнэх эрчим хүчний зорилтот түвшнийг тогтоож хэрэгжилтийг хангуулах, хэрэглэгчийн хэмнэлтийг хэмжих, тооцох, баталгаажуулах зохицуулалтыг бүрдүүлэх /Эрчим хүчний зохицуулах хороо/.
- 4.3 Эрчим хүчээр хангах гэрээг шинэчлэн байгуулах, үүнд эрчим хүчний хэрэглээний болон чадлын төлөвлөгөө, оргил цагийн оролцоог нарийвчлан тооцуулах, ухаалаг тоолуур ашиглах асуудлыг тусгах /Түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид, үүрэг хүлээсэн хэрэглэгчид/.

Тав. Эрчим хүчний үнэ цэн, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг олон нийтэд таниулах, сурталчлах, ерөнхий боловсролын сургалтаар хүүхдүүдэд хичээл заах, хүүхдүүдээр дамжуулж эцэг эх, нийгэмд нөлөөлөх ажлыг хэрэгжүүлэх /Эрчим хүчний зохицуулах хороо, тусгай зөвшөөрөл эзэмшигчид, боловсролын байгууллагууд/.

Зургаа. Эрчим хүчний үйлдвэрлэлийн техник, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хэмнэлтийг бий болгох, үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чиглэсэн олон улсын хамтын ажиллагааны шинэ боломжуудыг ашиглах.

Долоо. Эрчим хүчний хэмнэлтийн ЭСКо төсөл, хөтөлбөрүүдийг дэмжсэн хөрөнгө оруулалт, бага хүүтэй зээлийн эх үүсвэрийг бүрдүүлж хэрэгжүүлэх санал боловсруулж Засгийн газарт танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулах /Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо/.

Зөвлөгөөнд оролцогчид зөвлөгөөний үеэр гарсан шинэ санал, санаачилгыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, харилцан туршлага солилцох, хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд үр дүнтэй хамтран ажиллаж энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэхийг дэмжлээ.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх нарийвчилсан хөтөлбөр, төлөвлөгөөг Эрчим хүчний сайдын зөвлөлд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулах, Зөвлөмжийн хэрэгжилтийг хагас жил тутам хэлэлцэн үр дүнг мэдээлэхээр тогтлоо.